

СЭТГҮҮЛЧ Г.ДЭЛЭГИЙН АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ОНЦЛОГ,
УР ЧАДВАРЫН АСУУДАЛД

Ц.Чойсамба*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг: аян замын тэмдэглэл, уран дүрслэл, тоо, баримт, зохиогчийн оролцоо, сэтгүүлчийн ур чадвар, бичлэгийн өнгө аяс

Гэндэнжамцын Дэлэг бол Монголын сэтгүүл зүйд өөрийн гэрэлт хөшөөг босгосон эрхэм бөгөөд энэ салбарт хүч сорьсон хүн бүрт тэр бүр заяадаггүй ховорхон хувь тавилан түүнд ногджээ. Тэрбээр оюунлаг эрдэмтэн, авьяаслаг сэтгүүлч, чадварлаг сурган хүмүүжүүлэгч байсан юм.

Г.Дэлэг 1924 оны 3-р сарын 15-нд Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг Гардитолгой гэдэг газар төржээ. Тэрбээр есөн настайдаа Улаанбаатар хотод ирж, 1933-1935 онд нийслэлийн үлгэр жишээ бага сургууль, 1935-1939 онд дунд сургууль, 1939-1942 онд багш нарыг бэлтгэх сургууль, 1950-1953 онд ЗХУКН-ын дэргэдэх Намын дээд сургуулийг сэтгүүлч мэргэжлээр тус тус дүүргэж, улмаар 1965, 1973 онд ЗХУ-ын Нийгмийн ухааны академид дэд эрдэмтэн, докторын зэрэг хамгаалсан байна.

Г.Дэлэг 1942-1945 онд Ардын гэгээрлийн яаманд сайдын туслах, багш нарын болон холбооны

техникумд багш зэрэг ажил хийж байгаад 1945 онд «Пионерийн үнэн» сонинд нарийн бичгийн даргын албанд томилогдсоноор сэтгүүлчийн ажлын гараагаа эхэлжээ. Тэр үеэс хойш мөн сонины эрхлэгч, «Залуучуудын үнэн» сонинд орлогч эрхлэгч, 1953-1962, 1968-1979 онд «Үнэн» сонины орлогч эрхлэгч, ерөнхий эрхлэгч, «Тоншуул» сэтгүүлийн ерөнхий эрхлэгч, 1962-1968 онд МАХН-ын Төв Хороонд суртал нэвтрүүлэгч, хэлтсийн орлогч эрхлэгчээр ажиллаж байгаад 1979 оноос 1990 он хүртэл МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгчээр ажилласан байна.

Г.Дэлэг манай тогтмол хэвлэлүүдэд 200 орчим нийтлэл хэвлүүлсний дотор гадаад улс оронд аялахдаа бичсэн аян замын тэмдэглэлүүд нь хүндтэй байр эзэлдэг. Тэрбээр нийтдээ 100 орчим тэмдэглэл бичсэнийг гадаадын сэдэвтэй, улс орны дотоод амьдралыг харуулсан гэж ангилдаг. Аян замын тэмдэглэлийн 30 шахам хувь нь дотоодын сэдэвтэй болохыг судлаачид тооцоолон гаргасан байдаг¹.

Бид судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож «Монголын шилдэг нийтлэл»-ийн 12-р ботид нийтлэгдсэн, гадаад улс орнуудад зорчихдоо бичсэн аян замын 16 тэмдэглэлийг ашиглалаа.

Сэтгүүлч Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлүүдийн тухай олонтаа яригддаг боловч их эрдэмтний 75 жилийн ойд зориулж доктор Л.Норовсүрэнгийн тавьсан эрдэм шинжилгээний илтгэлийг эс тооцвол тусгайлан судалсан, нийтлэгдсэн бүтээл өөр үгүй юм. Иймд миний бие энэхүү сэдвийг сонгон авч, их эрдэмтний 90 жилийн ойд зориулж илтгэл тавихаар шийдлээ.

Г. Дэлэгийн аян замын тэмдэглэлийн тухай судлаач Л.Норовсүрэн: «Манай тогтмол хэвлэлүүдэд Г.Дэлэгийн бичиж гаргасан аян замын тэмдэглэлийн зарим нь өгүүлсэн арга хэлбэр, цар хүрээгээрээ аян замын найруулал ч гэж үзэж болохоор байдаг. Түүний тэмдэглэлүүд нэлээд задгай зохиомжтой, олон асуудлыг багтаасан, шинэ сонин мэдээллээр арвин байдаг онцлогтой. Зам зуурын ажиглалт, элдэв уулзалт яриа, шинэ улс орон, газар нутаг, хот орныг үзээд төрсөн сэтгэгдэл, тэдгээрийн нийгэм, улс төр, эдийн засгийн хурц, тулгамдсан асуудлууд Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлийн баялаг материал болж өгдөг байна. Тэрбээр аян замын тэмдэглэлийг ямар ч бодлогогүй аяллын протокол, тэмдэглэл болгохоос байнга сэрэмжилж, соён гэгээрүүлэгч, шинэ газар нутаг, харь ард түмний амьдрал тэмцэл, зан заншил, хөгжил дэвшлийн нууцыг нээн харуулж, танин мэдүүлэгч, гэгээрүүлэгч шинжтэй байлгахыг эрмэлзсэн байдаг. Энэ чанараараа түүний аян замын тэмдэглэлүүд бусад газар орон, ард түмний амьдралыг өргөн дэлгэр үзүүлж, гадаад дотоодод болж байгаа үйл явдлыг ойлгоход тусалж байдаг»², «Г.Дэлэг нийтлэл бүтээлийнхээ санаа сэдвийг урьдаас бодож олоод арвин баялаг материал цуглуулж, түүнийгээ нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх замаар

нягт нямбай боловсруулж, даацтай юм бичдэг сэтгүүлч байжээ. Түүний бичсэн нийтлэлүүд амьдралд ойр, үнэмшил итгэл төрөхүйц бөгөөд монгол ардын ярианы амьд хэлийг өргөн ашиглаж, ардын зүйр цэцэн үг хэллэгийг оновчтой хэрэглэж, өөрөө ч гүнзгий санаатай, яруу аялгуутай хэлц үгийг олноор зохиож хэрэгтэй газарт нь шигтгэж бичдэг өвөрмөц барилтай сэтгүүлч байсныг олон баримтаар баталж болно»³ гэх зэргээр зөв зүйтэй ажиглалт хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг.

Сэтгүүлч Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлүүдийг уншиж байхад юуны түрүүнд уран дүрслэлийн мастер байсан нь түвэггүй ажиглагддаг. Түүний дүрслэлүүд уншигчийг хөтөлж, тухайн цаг үе, орчин байдалд оруулдаг. Хэрэв тэрбээр теле сэтгүүл зүйд хүчээ сорьсон бол гайхамшигтай зураглаач байх байж гэсэн бодол төрснийг нуух юун. Зохиогчийн үзсэн харсныг уншигч бичсэн мөрүүдээр нь дамжуулж өөрөө үзэж харснаас өөрцгүй мэдэрдэгт сэтгүүлч Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлүүдийн бичлэгийн ур чадвар оршдог. Жишээ дурдъя:

«Биднийг Баден хотын төв хэсэгт байдаг "Статдвин" гэдэг зочид буудлын оройн хонгилд эвтэйхэн зассан өрөөнд суулав. Энэ хот хориодхон мянган хүнтэй ч гэсэн авто машин олонтой, хөл үймээн ихтэй, дуу шуугиан тасардаггүй ажээ. 11 дүгээр сар дөхөж, Монголд намрын сүүл сар шувтарч байхад Бадены зүлэг цэцэрлэг ногооноороо, модны мөчир саянаас шаралсхийж хүмүүс зуны хувцастай ганц нэг цув өмсч яваа харагдана. Хотын гудамж зарим газартаа дэндүү нарийсч хоёр машин арай чарай зөрөлцөхөөр юм. Явган хүний зөрөг зам зарим үед хоёр хүн зэрэгцэн явах боломжгүй нарийсна.

Гудамж зээлээр зарлал чимэглэл их, шөнө нь өнгө өнгийн гэрэл сацарч, өдөр нь нүд эрээлжилмээр эрэн мяраан зурагт хуудас харагдана. Америкийн кока кола гэдэг чихэрлэг эсгэлэн ундаа авч хэрэглэхийг уриалж дуудахаас авахуулаад эмэгтэй хүн оймсны татуургыг биендээ яаж тааруулах ёстойг үзүүлсэн баримал бишгүй элбэг үзэгдэнэ. Гудамжаар өөдөгцөө шуумагтай энгийн бориг эд бөсөөр хийсэн биедээ таарсан цэвэрхэн хувцас өмссөн бүрх малгайтай эрэгтэйчүүл, бас нэг хоёр, гурван нохой ч хөтөлсөн хижээлдүү авгайнууд нилээд дайралдана. Үе үе авга өвгөнөө болов уу гэмээр настныг сугадаж түшсэн залуу эмэгтэйчүүл дайралдахад ач охид, бэргэнүүд буурал өвгөдөө асрамжлан тойлдож нар салхинд зугаацуулж явна уу, эсвэл хөрөнгө зоорьтой баячуул наргиж яваа ч юм уу бүү мэд дээ» («Австрид төрсөн сэтгэгдэл») гэсэн мөрүүдийг уншиж байхад Баден хотод очсон мэт, «Автобусанд олон орны сэтгүүлчид суужээ. Автобусны явдал дунд зарим самбаатай нь бичгийн машин тачигнуулж, бодож байснаа тэмдэглэн, олон хэлийн хүний яриа хөөрөө, тоглоом тохуу өрнөж, хөгжилтэй дуу цууриатаж байлаа» («Унгар нутгаар явахад») мөрүүдийг уншихад Будапештээс Дунайварошыг зорих автобусанд орон орны сэтгүүлчидтэй хамт яваа мэт сэтгэгдэл төрнө.

Байгаль дэлхийн үзэсгэлэнг сэтгүүлч Г.Дэлэг тун уран яруу харуулах ховорхон увдистай байжээ. «Лаос нутагт байгаль ёстой л нэг ураа гаргажээ. Эндхийн байгаль дэлхий цаанаа л нэг чамин. Илбэ увдис нь их хүчийг нууцалсан мэт гайхаш төрүүлж, анхаарал татна. Газраас ургасан мэт хэдэн зуун метр өндөр,

цул хадан хясаа энд тэндгүй сүндэрлэн дүнсэнэ. Өндөр сүрлэг ихэмсэг хадан уул өглөөний сэрүүнд манан нөмрөгөө тайлж нэг харахад инээх мэт, дахин ажиглахад уурлах мэт бараа сүр ихтэй, ер бусын үзэсгэлэнтэй харагдана. Эдгээр өндөр цавчим хадан уулыг юуханд ч болов тогтож ургахдаа адтай, халуу орны битүү ногоон ургамал хучиж, бүгдийг нь ижил төстэй болгожээ. Халуун орны ширэнгэ ой маш нягт ургасан нь тэнд хэдхэн алхахад гэгээн цагаан өдөр боловч харанхуй болно. Лаос орны дүр зураг яагаад ч юм бэ, олонтой ажиглагдсанаар ч тэр үү, униар суунагласан ширэнгэ ойн дунд замбага цэцгээр үсээ чимсэн гуалиг бүсгүйчүүд намуухан боловч уянга төгс дуу аялж, мяралзан урсан уулын цэнгэг зорхи руу нүцгэн хөлөөр нилээд дотогшилон орж урт хормойгоо үл мэдэг шууж, дамнуургандаа маш сурмаг ус утгаж байгаа байдлаар санаанд бууна» («Лаос нутгийн сонин») мөрүүдийг уншихад Лаос орны унаган байгаль нүдэнд бууна. Ийм уран яруу, барим тавим нүдэнд харагдаж, сэтгэлд буухуйц дүрслэлүүд сэтгүүлч Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлийн нэрийн хуудас болжээ.

1960-1970-аад оны монгол уншигчдад сонин содон санагдаж магадгүй үзэгдлүүдийг сэтгүүлч Г.Дэлэг гярхай ажиглаж, тэмдэглэлдээ оновчтой шигтгэж оруулсан байдаг. Тухайн үеийн уншигч олонд жигтэй санагдаж болох дараах дүрслэл өнөөгийн уншигчдад танил санагдаж магадгүй:

«Гудамжинд замын ногоон гэрэл түр хаагдахад зогсож байгаа машины өмнүүр алчуур барьсан залуу яах ийхийн завдалгүй харайлган ирж өмнөх шил тоостой, тоосгүй ялгалгүй арчиж гарна. Хэрэв явган хүн машины

урсгал хүлээн зогсож байвал хаанаас гарсан нь мэдэгдэхгүй цагаан цамцтай галстуктай үйлчлэгч залуу эндхийнхний маш дуртай уудаг хундага шиг бяцхан савтай өтгөн хар кофеэ гарт баруулж амжина. Тэгээд энд ч тавин лир, тэнд ч зуун лир гээд л хүний өвөр түрий дэхийг тун ч түргэн дундуруулна» («Коммунист»).

Харин казиногийн тухай «Монакод байдаг хамгийн томоохон байгууллага гэвэл мөрийтэй тоглоомын газар казино гээч юм. Казино гээч нь дотоод чимэг төхөөрөмж сайтай дотроо клуб үзмэртэй, зүйл зүйлийн үзмэртэй, мөрийтэй тоглоомын төрөл бүрийн төхөөрөмж бүхий том байшин юм. Казинод тавиас тавин мянган франк (нэг франк 74,72 мөнгөтэй тэнцэнэ) тавьж мөрийцэн тоглоод гучхан секундэд уул мөнгөний хувь заяа нэг тийшээ болдог. Энд италийн нэг баян, авгайнхаа хамт ирж мөрийтэй тоглоомд азаа туршиж өөрөө хоёр сая, авгай нь нэг сая франк тавьж ганц тоглоод л гар хоосон буцжээ. Мөн биднийг энд ирэхээс хэдхэн хоногийн өмнө тэр хязгаарт мөнгөний тулам нэг баян ирж ганц үдэш мөрийтэй тоглож гурван зуун тавин сая хуучин франкаа алдаж зугаацсаныг хөрөнгөтний хзелэл бардамнан хөөрч, халаглан харамсаж эсэн бусын юм бичсэн байж билээ. Мөрийтэй тоглоомын Монакын еангийн казинод мөнгөний дуу тасрахгүй хангинаж байна. Тэнд очсон хэн бүхэн мөрийтэй тоглоомд унаж гүйцсэн хүмүүсийн шунал бадарсан хурц нүд, мөн гунигт дарагдсан жаехаагүй нүд аль алиныг ажиглан харж болно. Тэр байшинд хөрөнгөтнийгмийн энэрэлгүй хатуу ёс, олзондоо омогшсон ганц нэг хүний овилгоогүй дүр, бас байдгаа алдаж

аргаа барж цөхөрч гүйцсэн олон хүний хөөрхийлэлтэй царай, гал нь буурсан нүдийг ч ажиглаж болно» («Номин цэнхэр эрэг») гэж өгүүлсэн нь дүрслэлийн хувьд тод томруун болжээ.

Сэтгүүлч Г.Дэлэг антагонист хоёр системийн зөрчлийг харуулах, түүний дотор социалист орнуудын бүтээн байгуулалт, капиталист орнуудын ялзрал, хямралыг тодорхой тоо баримтаар илтгэхийг зорилгоо болгож байсан нь анзаарагддаг. Түүний аян замын тэмдэглэлд үзэл сурталжсан, намжсан, шашингүйн үзлийг сурталчилсан зүйл багагүй байдгийг судлаачид тэмдэглэсэн нь бий. Гэхдээ сэтгүүл зүй бол тухайн цаг үеийн бүтээгдэхүүн, тусгал байдаг, байсаар ирсэн, байх ч учиртайг бодолцвол сэтгүүлч Г.Дэлэгийг ойлгоход түвэггүй. Ер нь үзэл суртлын, коммунист сэтгүүл зүйн үеийн бүтээлийг орчин үеийн, чөлөөт, ардчилсан сэтгүүл зүйн шаардлага, зарчмын үүднээс үнэлж дүгнэх нь утгагүй юм.

Сэтгүүлч Г.Дэлэг «...Гадаадын улс оронд явснаа урьтал болгон сайрхаж, ууж идсэн, уулзаж учирснаа хөврүүлэх биш, нэг нарны доор, нэгэн зорилгын төлөө аж төрж байгаа дэлхийн хүн ард, хөдөлмөрч сэхээтний амьдрал тэмцэл, хүсэл тэмүүлэл, түүнд нөлөөлж байгаа нийгэм, улс төрийн хүчин зүйлүүдийг бодитой илэрхийлэх чиглэлүүдийг тууштай барьж, ултай бодож сэтгэж, бичиж боловсруулдгийг нь түвэггүй мэдэж болохоор байна»⁴.

Тэрбээр ялангуяа хуучин, шинэ хоёр нийгмийн зөрчлийг гаргахад, тэгэхдээ колоничлол, империализмын боолчлолыг давж, социализмыг цогцлоон байгуулж буй ард түмнүүдийн үйлс бүтээлийг дэлгэн харуулахад ихээхэн анхаарч, ач холбогдол өгч байжээ. Ийм нийтлэлийн тоонд Куба, Лаос, Болгар

зэрэг оронд зорчсон тэмдэглэлүүд хамаарна.

«Би л болбол, манайх л болбол бусад нь хамаагүй гэдэг хуучны аминцар үзэлтэй тариачны ухамсар өөрчлөгдөж хамтын хав, олны олз их гэдгийг аргагүй ойлгож үр хүүхдийн төлөө, улс гүрний төлөө гэдэг ухамсар, үзэл санаа бий болж, одоо харин хагас сард багтааж хийе гэснийг араа хоногт, бүтэн сард багтааж хий гэснийг хорь хоногт амжуулан, хичээл анхаарал гаргаж хий гэснийг чанар үзэмж сайтай, цэвэр цэмцгэр хийдэг боллоо...

Ажилчин хүнээс татдаг орлогын татвар нь ажилчны авдаг цалин

хөлснөөс хоёр гурав дахин илүү гарч байв. Тийм татварыг ажилчин хүн яаж төлдөг байв гэвэл эцэг өвгөд, элэнц хуланцын үеэс хурааж хуримтлуулсан аль өнгөтэй өөдтэйгээ өгч, эс дийлбэл эхнэр хүүхдээ татвар төлөөсний золионд худалдаж, эзэн захирагчийн хаяа хатавчны барлаг зарц болгож байв. Энэ үеэр хайх мөр, хандах зүггүй алга болсон хүн ч манай нутагт олон юм. Татварыг ажилчин, тариачнаас татахдаа ам бүлийн татвар, байр сууцны татвар, эд хогшил, эзэмэг бөгжийн татвар, морь үхрийн татвар, гахай тахианы татвар, галуу нугасны татвар, бүр болиод хот суурингаар тэнэдэг эзэнгүй муур нохойн татвар гэж ч авдаг байлаа. Эхнэр хүүхнүүдийн мээм том бол бас татвар авдаг байлаа. Ай зайлуул, тэр бүгдийг эс төлбөл

нэгжлэг хийж, эд хогшлыг нь хурааж, шорон гянданд хорьж, харь газар цөлж хатуу чанд залхаадаг байлаа...

Тэднүүс бие хүч, бэл хөрөнгө муутны зөв бурууг ялгахгүй эрүү шүүлт тулгаж, гав дөнгө зүүж, олс дээрээс хүлж, агтлан татаж нуруу бөгсгүй банздаж, ард амьтдыг мөн ч их тарчилгаж байлаа. Миний нэг хамаатанг согтуу хөлчүү гуйеж явна

гэж тархи толгойгүй зодож эрэмдэг зэрэмдэг болгохыг би нүдээр үзлээ. Өөр нэг хүнийг өмнөөс хэдэр үг хэллээ гэж шууд буудаж алахыг би бас харлаа. Чих хурдал, нүд үнэнч гэдэг. Орчлонд олон оймс элээсэн би барин тавин харсныгаа хэлж байна...

«

Г.Дэлэг ялангуяа хуучин, шинэ хоёр нийгмийн зөрчлийг гаргахад, тэгэхдээ колоничлол, империализмын боолчлолыг давж, социализмыг цогцлоон байгуулж буй ард түмнүүдийн үйлс бүтээлийг дэлгэн харуулахад ихээхэн анхаарч, ач холбогдол өгч байжээ

»

Олз олбол баян хангайн хишгээс аль олигтойг эзэн захирагчид барих ёстой. Өөрийн юмыг хийхээс өрсөж, эзний юмыг хий, өөрийн газарт ажиллахаас өмнө эзний газарт ажилла гэнэ. Өнгөтэй өөдтэйг өөрснөө хэрэглэх ёсгүй, амттай аятайг өөрснөө идэх ёсгүй. Шувуу шиг эрт босч, адуу шиг орой унтаж, борви бохисхийлгүй ажиллаач сайн нэр огтхон ч дуулдахгүй байлаа. Бусдын колони байна гээч иймэрхүү амьдралыг хэлдэг юм байна билээ.

Вьетнам, Лаосын нутгийн аль альнаар ч явсан дайнд эвдэрч сүйрсэн зам гүүр, бөмбөгдлөгт өртсөн галт тэрэгний урт цувааны сэг, орон сууцны үлдэц, шатаж хүйхлагдсан ой шугуй бөмбөгөөр онги авахуулж сэндийлүүлсэн тариан талбай, голдоо 4-5 метр гүн бүхий дугуй цоохор

толбоор дүүрсэн уул толгод хаа сайгүй дайралдана. Бидэнтэй хамт явсан Кон Саван угаасаа цэргийн хvн учраас Америкийн бөмбөг ойчсон газрыг хармагц зааж зургаан ханатай гэрийн буурийн чинээ нүхийг энэ бол зуун килограммын бөмбөг ойчсон газар байна, ёроолд нь тогтсон усанд тэр эмэгтэйн юм угааж байгаа хонхорт бол таван зуун килограммын бөмбөг унасан байна гэх зэргээр тодорхойлон ярьж явлаа.

Дайн дажны ул мөр одоог хүртээ хэвээр байгааг Лаосын олон агуйд гэрчилж байна. Бүхэл бүтэн ард түмэн агуйд хорогдож амьдарч байна. Жишиж хэлэхэд айл өрх болгон агуйтай, зочид буудал, албан газар, кино, театр, цирк, агуйд хэвлэх үйлдвэр, радио станц, өргөн нэвтрүүлэг, сургууль эмнэлэг, хоршоо дэлгүүр, фабрик, завод цөм агуйд ажилласаар байна» хэмээн харийн дарангуйлалд нухлуулсан ард түмний хөөрхийлэлтэй дүр зургийг «Лаос нутгийн сонин»-д нүдэнд үзэгдэлт өгүүлжээ.

Тэгвэл «Кубын хувьсгал» аян замын тэмдэглэлд: «Хөнгөн хүнсний үйлдвэрийг хөгжүүлэх талаар Куба орон ихээхэн анхаарч байсныг ганц нэг жишээгээр дурдахад 1958 онд Кубын гутлын үйлдвэрүүд арван нэгэн сая хос гаруй хос гутал гаргаж байсан бол 1975 онд гучин сая хос гутал үйлдвэрлэж, элдэв төрлийн цаас үйлдвэрлэх хэмжээг хоёр хагас дахин өсгөж утас зүүгээ хүртэл Америкаас зөөж байсан арчаагүй байдлыг аль хэдийн өөрчилж гаднаас авч байсан нилээд төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, өргөн хэрэглээний барааг өөрснөө үйлдвэрлэх болжээ. Хувьсгалын өмнө Куба орны хөдөө аж ахуйд есөн мянган трактор ажиллаж байсан бол одоо

чадал хүч хавьгүй илүүтэй тавьж дөрвөн мянган трактортой тавьж тариалангийн талбайг хоёр болж дахин өсгөжээ. Сахарын ургацыг хураах, үйлдвэрлэх ажлыг механикжуулж сайжруулсны ачаар хоёр зуугаа мянган ажилчныг өөр үйлдвэрлэлд шилжүүлжээ. 1958 онд Куба орон арван хоёр сая песогийн янжуур гадаадад гаргаж байсан бол ноодон жил хорин найман сая песогийн янжуур гадаадад худалдаалав.

Кубад хувьсгалын өмнө хүн амын дундаж нас тавин тав хүрэхтэй үгүйтэй байсан бол одоо дал хүрэх болжээ... Урьд тосгоны хүүхдүүдийн ерэн хувь нь хөл нүцгэн бойжиж, өвчин эмгэгтэй хууч согогтой хүмүүс олширч, гуч хүрээгүй байхад аманд нь бүтэн шүд үлддэггүй байжээ... Тэр үед нэг роман худалдаж авъя гэвэл дөрвөн доллар хүрч ажилчин хүний өдөртөө авдаг орлогоос хамаагүй давж байсан зэрэг нь империализм колоничлолын бурангуй үе хүн ардын гэгээгч соёлжихыг гаргуунд нь тавьдгийн жишээ байлаа. Кубад хувьсгалын өмнө нэг сая хүн бичиг мэдэхгүй, нэг сая гаруй хүн бичиг бага мэдэж, найман зуун мянган хүүхэд сургуульд яваагүй байсан бол одоо үнэн хэрэг дээр Куба оронд бичиг үсэг үл мэдэх явдал бүрэн устаж, бүх хүүхдээ сургуульд хамруулж зөвхөн сүүлийн таван жилд найман зуу гаруй элдэв шатны сургуулийн барилгаа байгууламжийг шинээр ашиглалтад оруулж мөн хувьсгалаас өмнө жилд чүү ай ганц сая хүрэхтэй үгүйтэй ном хэвлэж байсан бол одоо жилдээ 35 сая ном хэвлэн гаргадаг болжээ» гэх зэргээр тодорхой тоо, баримтаар хуучин, шинийн ялгааг харуулжээ.

Социалист, капиталист ертөнцийн хооронд орших алд дэлэм ялгааг

«Үзэсгэлэнт сайхан Болгар орноор» тэмдэглэлдээ дараах байдлаар илтгэсэн байна: «Балканы хойг хага үсэрсэн шиг түүний нэг хэсэгт Болгар, Румын орон социализмын замаар урагшаа суа үсрэн хөгжлөө. Балканы хойгийн нөгөө хэсэгт Грек, Турк орон хуучин хоцрогдолдоо баригдсан хэвээр ахиж дөхсөн юмгүй бахь байдгаараа үлджээ... Болгарын аж үйлдвэрийн 1939 онд жилийн турш үйлдвэрлэж байсан зүйлийг одоо ганц сарын дотор гаргаж байна. Сүүлийн нэгэн жилд Болгарт нэг хүнд 100 өндөг, 60 литр сүү, 30 кг мах оногдож байсан бол Туркт нэг хүнд 30 өндөг, 19 литр сүү, 17 кг мах оногдож байсан баримт Балканы хойгийн хоёр хэсэгт хүмүүсийн аж байдал ямар болохыг харуулж өгнө».

Зохиогч боломж л гарвал хөрөнгөтний нийгмийн тогтолцооны гажуудал, сул талыг чимхэж байсан нь дараах жишээнээс илэрхий: «Парис гаднаасаа сайхан хот юм. Гял цал юм ихтэй», «Зөвхөн Парист сая гаруй хүн орон сууцаар гачигдаж байна» («Хал үзсэн буурал хот»), «"Аполлон-11" гэдэг хөлөг саран дээр амжилттай бууж, америкийн сансрын нисэгчид сарны чулуу түүж хөлс хүчээ барж ирсэн тэрүүхэн цөөхөн мөчид эх дэлхий дээр маань 36550 хүн өлсөж үхсэнийг өлсгөлөнтэй тэмцэж Ирландын үндэсний хороо албан ёсоор мэдээлж байсан баримт орчлонгийн олон хүний сэтгэлийг түгшээж байна» («Очир алмас»), «"Франкфуртийн бүх нийтийн сонин" хэмээх тус хотноо гардаг засгийн газрын өдөр тутмын сонин дугаарт "Манайд сургууль төгссөн таван хүний дөрөв нь ажил мэргэжилт олох боломжгүй, хий эрэлд хатаж... тэдэнд амьдралын золгүй хувь тавилан бэлэн зэхээстэй байна»

гэж ганц ч атугай гашуун үнэнг хүлээн зөвшөөрсөн» («Дөрвөн тивийн буудалд»), «Нийслэлд [Ром — Ч.Ч.] үйлдвэрлэл буурч, бүтээгдэхүүний өсөлт багасч ажилгүйчид нэмэгдэж байв. Гурван сая гаруй хүнтэй энэ хотын зургаан зуу мянга гаруй хүн хотын нуранги оромжид толгой хоргодож, ус цахилгаан, орчин үеийн үйлчилгээний бусад төхөөрөмжөөр гачигдан зүдэрч байна. Энэ хотноо 250 мянган хүнд огтхон ч ажил олдохгүй байгаагийн дотор ажилгүй залуус нэг бум хүрчээ» («Коммунистууд») г. м.

Колониализм, империализм, бурангуй тогтолцоо, шударга хүн төрөлхтний эсрэг харгис дайн дажныг зохиогч үнэн голоосоо жигшин зэвцүүцэж, үзэн ядаж байгаа нь түүний нийтлэлүүдээс мэдрэгддэг. «Аяа, Америкчууд ухаантай мөртлөө ямар тэнэг вэ? Азийн энэ жаахан орныг оршин суух газаргүй болтол бөмбөгддөгийн учир юу вэ? Америкчууд Нью-Йорк, Чикаго хотынхоо олон давхар байшинд орогнож, хоол зуушныхаа газруудад сууж, дарс ундаагаа ууж, наргиж наадахад нь, Америк эхчүүд үр хүүхдээ бөөцийлж, хүүхэд шуухад нь үзсэн харсанаа дуурайж, тоглож наадаж өсөхөд нь Азийн тэртээ буланд байгаа Лаосчууд юугаар дараа тээр болоо вэ гэж асуумаар санагдана» («Лаос нутгийн сонин») гэсэн өгүүлбэрт сэтгүүлч Г.Дэлэгийн хүнлэг, энэрэнгүй үзэл нэвт шингэжээ.

Сэтгүүлч Г.Дэлэг аян замын тэмдэглэлүүддээ тоон баримтыг тэр бүр ашиглаад байдаггүй боловч онож шигтгэх онцгой авьяас, мэдрэмжтэй болох нь түвэггүй анзаарагддаг. Цөөн хэдэн тоогоор ерөнхий дүр зургийг тод томруун харуулж, уншигчийн ой тойнд

буутал өгүүлдэг нь түүний ур чадварын нэг илрэл юм.

Энэтхэг-Хятадын хойг дахь түрэмгий дайны мөн чанарыг «Америкчууд Лаосын чөлөөлсөн нутгийн 450 сүм дуганыг бөмбөгдөж, эрхэмлэн тахидаг нэг мянга гаруй нандин бурхан шүтээнийг устгаж, бурхны ном, хөлгөн судар 19 мянган ботийг бүрэлгэв... Францын колоничлолын үед Лаосын хүн амын 95 хувь нь бичиг мэдэхгүй байлаа. Колоничлогчид тэгэхэд ганц ч алхам төмөр зам тавьсангүй, ганц ч олигтой фабрик завод барьсангүй, ганц ч дээд сургууль байгуулсангүй» («Лаос нутгийн сонин») гэж харуулсан бол Парис хотыг «зам харилцаа сайтай юм. Уртаараа 170 км метро, хотын эргэн тойрноос 11 тийшээ салаалсан төмөр зөм, 1500 салаа засмал зам бас усан зам энэ бүгд хотыг нэвт шувт сүлжиж хотын орчин тойронд нисэх онгоцны 15 буудал байгуулжээ» («Хал үзсэн буурал хот») хэмээн дүрсэлж, харин Сибирийн баялгийг «Сибирийн уудам нутаг байгалийн хийгээр маш баялаг. Зөвхөн 1975 онд баруун Сибирис 37 миллиард шоо дөрвөлжин метр хий олборлосон бол Х таван жилд Сибирийн байгалийн хийн үйлдвэрлэлийг 3-3,8 дахин өсгөхөөр төлөвлөжээ. 1980 онд Зөвлөлт Холбоот Улс 400-435 миллиард шоо дөрвөлжин метр шатдаг хий хэрэглэх бол түүний 125-155 миллиард шоо дөрвөлжин метрийг Сибирис авч юм. Зөвхөн ганц Баруун Сибирийн шатдаг хийн нөөц нь 15 триллион шоо дөрвөлжин метр байхад Америкийн шатдаг хийн бүх нөөц тэдний тодорхойсноор 8 триллион шоо дөрвөлжин метр хавьцаа байна» («Баян уудам хязгаар») зэргээр илэрхийлжээ.

Түүнчлэн социалист бүтээн байгуулалтын далайцыг харуулахад сэтгүүлч Г.Дэлэг тоо баримтуудыг өргөн ашигласан байдаг. Тухайлбал: «Хориод оны үеийн тоотой харьцуулбал Зөвлөлт Киргизийн хүн ам дөрөв гаруй дахин өсч, одоо гурван сая 723 мянган хүн амтай болжээ. Ер нь 1000 хүн тутмаас төрөлтийн тоогоор Киргиз улс бүх Зөвлөлтийн дунджаас 2,5 дахин их байна. Жаран жилд Зөвлөлт Киргизэд цоо шинээр 12 хот, 30 гаруй хот маягийн тохиожсон суурин байгуулагджээ» («Нарлаг Киргиз орноор»), «Арван таван дээд сургууль, арван зургаан театр, зуу гаруй кино театр, хорин таван музей, хоёр зуун тавин мянган сурагч энэ бүхэн өнөөгийн Будапешт хот Унгар дахь социалист соёлын томоохон төв болохыг тодорхойлж байна. Дунайварош хотын иргэд найман мянган радио, радио хүлээн авагч, гурван мянга гаруй зурагт радиотой байгаа юм. Энэ хотын хөдөлмөрчдийг худалдаагаар үйлчлэх зуугаад дэлгүүр, тавиад шугам чиглэлд явах автобусны үйлчилгээ, найман мянга шахам сурагчтай бүрэн бус дунд сургууль, зургаан техникум, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд саатуулах хориод газар, гурван кино театр, хоёр мянган хүний суудалтай ногоон театр, таван мянган хүний суудалтай биеийн тамирын ордон зэрэг нь тус хотын хүн амын боловсон чинээлэг аж байдлыг аяндаа ойлгуулах юм» («Унгар нутгаар явахад») зэрэг жишээг дурдаж болно.

Сэтгүүлч Г.Дэлэг аян замын тэмдэглэлүүдээ бичихдээ үзсэн харснаараа хязгаарлахгүй, үүх түүхээс нь дэлгэдэг арга барилтай ажээ. Жишээ болгож «Чехословакт хийсэн тэмдэглэл» («Прагийн дундуур урсах Влгав гол дээр барьсан Карлын

гүүр хэмээх зургаан зуугаад жилийн түүхтэй чулуун гүүр 1393 онд католик шашны тэргүүн хамба Ян Непомуцкийг шуудайд хийж усны цүнхэлд залсан домгийг санагдуулж байна. Манай тооллын есдүгээр зууны үеэс эхэлж байгуулагдсан Прагийн кремль Чехийн улс төр, нийгмийн амьдрал, түүхт үйл явдлыг чулуун хэрэмдээ тод томруун тусгажээ. Чехийн түүхэнд болсон их өөрчлөлтүүдийг өөрчлөгдөн солигдсон олон үеийн гайхамшигт уран гартан Прагийн кремлийн энэхүү чулуун барилгад шингээн үлдээжээ... Баруун Чехийн дулаан гол гэгчийн сав газарт байдаг Карлово Варын рашаан усны эмнэлгийн чанар нь их дээр үеэс мэдэгдэж байсан боловч сүүлд 1348 онд амралт сувиллын газрыг нээж, 1370 он гэхэд тэнд бүхэл бүтэн хот бий болсон», «Ханжоу хот» («Ханжоу хотод Хятадын эртний домогт эх оронч Юй Фэйн шарилыг таьж дурсган босгосон орд харш байна. "Юй Фэйн эх нь хүүгийн ар нуруун дээр "Эх орноо үнэнчээр хамгаал" гэж зүүгээр шивж бичсэн юм" гэж тэндхийн хүмүүс хэлдэг байна. Харийн түрэмгийлэгчдийг баатарлагаар эсэргүүцэж эх орны өмнө шударгыг гүйцэтгэсэн Юй Фэйн шарилыг онголон оршуулж, тэр шарилын өмнөөс харуулж, хайрт эх орончийг хорлон алсан феодалын зальхай түшмэлийн мэхийн сөгдсөн гутамшигт дүрийг ширмээр цутган тавьжээ. Ингээд олон үед түүгээр тойрон үзэгчид тэр жишгүүрт дайсныг хорсон занаж, түүний бузар гутамшигт дүрс дээр чулуу ороо цацаж, нулимаж байдаг байжээ») зэрэг тэмдэглэлийг дурдаж болох юм.

Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлийн бичлэгийн ур чадвар, өвөрмөц арга барилыг судлаачид онцлон тэмдэглэ-

сэн байдаг. Тэрбээр монгол бичгийн хэлний тэгш хэмтэй найруулах, толгой холбох, сондгойруулахгүй байх зарчмуудыг нарийн баримталж нийтлэлүүдээ туурвижээ.

Г.Дэлэгийн бичлэгийн нэрийн хуудас болсон холбоо болон цэцэн мэргэн үгсээс дурдвал: «ууц ороож, хөл тушсан хээнцэр хувцастай» («Унгар нутгаар явахад»), «зовлон дунд зоригжиж, гаслан дунд хатуужсан кубачууд», «буу барьсан цэргүүдээр дүүрч байсан хуучин хуаран, үзэг барьсан хүүхдээр дүүрсэн сургууль болжээ», «хангайн уул шиг нөмөртэй, халуун нар шиг ивгээлтэй», «Америкийн эзэрхгүүдийн омгийг нь дарж, омрууг нь огтолсон», «Куба хартан хардаж болохгүй, хортон хоргодож чадахгүй тийм орон болсон», «Америкийн империалистуудын голы нь харлуулж, горийг нь таслах» («Эрэлхэг зоригт Куба! Бид чамтай хамт»), «хөрөнгөтнүүдийн гол нь гонсойж сэтгэл нь харлаж байна», «борвийг бохийлгохгүй, гарыг хумхиулахгүй» («Хал үзсэн буурал хот»), «хамтын хав, олны олз их», «нэр нимгэн, цол цомхон», «араа шүдээ хавирч, өлөн нүдээ хялалзуулж», «үзэшгүй бузар, өгүүлшгүй булай явдал», «уулгалан давшилж улангасан дайрч» («Лаос нутгийн сонин»), «энх сууж, мөнх жаргаж», «далайг хөөвөлж, уулыг ороож», «алхвал алт, мөлхөөл мөнгө» («Номин цэнхэр эрэг»), «харгүйд явахад хамаг юм тохиолдож, ажлаар явахад аль ч юм дайралддаг», «хүн удмаараа алдаршдаг биш ухаанаараа алдаршдаг», «үсэг муруй ч үг шулуун» («Очир алмас»), «ойроос үзэж холоос сонссоноо танилцуулъя» («Дөрвөн тивийн буудалд»), «дундуурыг дүүргэж, дутууг гүйцээх» («Коммунист») г. м. толгой холбосон цэцэн

мэргэн үгс тэмдэглэлүүдийг чимж, зохиогчийн бичлэгийн давтагдашгүй өнгө аясыг илтгэдэг.

Сэтгүүлч Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлийн өөр нэг онцлог бол зохиогчийн «нуугдмал» байдал юм. Өөрөөр хэлбэл, бид харь орны соёл, зан заншил, хүмүүс, бүтээн байгуулалттай танилцахдаа зохиогчийг тэр бүр олж хархгүй. Зохиогчийн «Би» бараг өгүүлбэр тутамд мэдрэгддэг орчин үеийн аян замын зарим тэмдэглэлээс сэтгүүлч Г.Дэлэгийн нийтлэлүүд энэ шинжээрээ хол давуу юм. Түүний тэмдэглэлүүдийг уншиж байхад зохиогч хүүрнэл дундаасаа хэдхэн удаа л «гарч ирдэг». Тэгэхдээ уншигчидтай үзэл бодол, байр сууриа хуваалцаад буцаад хүүрнэл дундаа уусдаг. Энд хоёр тэмдэглэлээс жишээ татъя:

«...Дараа цамхагийн зургийг авах гэж аппаратаа зэхтэл: - Мсье. Мсье! хэмээн хажуунаас чанга хашгирч гүйхээрээ айсуй. "Энд зураг авч болохгүй юм болов уу?" гэж бодтол төдхөн байдал тодорхой болж: -Та ядуу зурагчны хоолноос хороож яах нь вэ? Би хэрэгтэй зургийг чинь аваад өгье гэж билээ. Тэр зурагчны үг, түүнээс хойно уулзаж учирсан хүмүүсийн үг надад нэлээн юм бодуулав», «Ажилчдын үг яриаг сонсож аж байдлыг нь ажиглахад Францад сургааль орон сууц барихаасаа завод фабрик барьдаг гэдэг нь яриагүй үнэн юм даа гэж бодогдож байе», «Гудамжинд явган хүний улаан зам дээр хүүхэд зураас татан тоглож байхад зорчигчид цөм түүнийг нь зөтэйхэн тойрон гарч байхыг харав. Бяцхан хүүхэд задгай газар тоглож байгаа концерт харах гээч амьтны ар өөрөөр бултганаж явахыг хармагц нөгөө хүүхдийг хажуугийн үл таних хүн өргөж хүзүүн дээрээ мордуулан юм

харуулах зэргээр Францын жирийн хүмүүс хүүхэд багачуудыг эвийлж хайрлаж байгааг хараад сэтгэлд олон юм бодогдлоо» («Хал үзсэн буурал хот»), «"Би өөрөө гурван ч удаа Америкийн шоронд хоригдож үзэе. Өөрийнхөө биеийг зогсож багтахаар нүх малтаж амьдаараа шороонд булуулж ч үзлээ" гэж америк маягийн эрх чөлөө гэдгийг биеэр амссан, бас тэр эрх чөлөөг эдэлж амиа алдаж тарчилж зовсон нөхдийгөө нүдээр үзсэн Лаосын эх орончдын нэг Фен гуай дэлгэрэнгүй ярихад нь би манайхны хэлдгээр "Улаан төмөр долоож, улныхаа махыг элээсэн хүн" гэдэг ийм байдаг болов уу гэж дотроо бодож байж билээ» («Лаос нутгийн сонин»).

Сэтгүүлч Г.Дэлэгийн аян замын тэмдэглэлүүд зохиогчийн ертөнцийг үзэх үзлийг нэг хэлбэр болсон бөгөөд бичлэгийн өвөрмөц арга барил, содон өнгө аяс, давтагдашгүй найруулгаараа Монголын нийтлэлийн өвд хүндтэй байр эзлэх, одоо ч танин мэдэхүй, соён гэрээрүүлэх ач холбогдлоо алдаагүй бүтээл мөн.

Ишлэл

2001. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. УБ., 371, 374 дэх тал.
2005. Норовсүрэн Л. Монголын нийтлэл. Дэд дэвтэр. УБ., 423-424 дэх тал.
2014. Монголын шилдэг нийтлэл. Г.Дэлэг. Боть 12. Эмхэтгэж редакторласан Л.Норовсүрэн. УБ., 11 дэх тал.
2001. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. УБ., 372 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

2014. Монголын сэтгүүл зүйн нэрт судлаач Гэндэнжамцын Дэлэг. Бичиж

бэлтгэн, хэвлэлд эмхэтгэсэн Т.Баасансүрэн, Б.Уянга. УБ.

2. 2014. Монголын шилдэг нийтлэл. Г.Дэлэг. Боть 12. Өмнөх үг бичиж, эмхэтгэж редакторласан Л.Норовсүрэн. УБ.

3. 2001. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. УБ.

4. 2005. Норовсүрэн Л. Монголын нийтлэл. Дэд дэвтэр. УБ.

5. 2013. Норовсүрэн Л., Баасансүрэн Т., уянга Б. Сэтгүүл зүйн нэрт судлаач Гэндэнжамцын Дэлэг // Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал. УБ.

6. Зулфикафиль М. 2010, 2011. Сэтгүүлчийн ур чадвар. I-III дэвтэр. УБ.

Резюме

Автор анализирует творчество, в частности путевые заметки, и раскрывает проявления мастерства Г.Дэлэга – крупного учёного, талантливого журналиста и замечательного педагога. Из почти 200 публикаций, опубликованных им в монгольской печати, автор для исследования выбрал 16 путевых заметок, написанных во время или после поездки в зарубежные страны – социалистические, капиталистические или третьего мира. Хотя в них чувствуются элементы идеологии, автор считает, что они являются примером высокого журналистского мастерства.